



МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛИЙН  
РЕКТОРЫН ТУШААЛ

2023 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/363

Улаанбаатар хот

Оюутны журам шинэчлэн батлах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2, МУБИС-ийн Ректоратын зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хурлын шийдвэр, МУБИС-ийн дүрмийн 4.4.1, 4.4.5 дахь заалтыг үндэслэн тус тус ТУШААХ нь:

1. Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн "Оюутны журам"-ыг шинэчлэн хавсралтаар баталсугай.

2. "Оюутны журам"-ыг оюутан, багш, ажилтнуудад танилцуулж, батлагдсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг бүрэлдэхүүний сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сургалт, хамтын ажиллагааны газрын даргын үүрэг гүйцэтгэгч (Д.Соронзон)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан МУБИС-ийн захирлын 2018 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/333 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

РЕКТОР  Ж.БАТБААТАР

20273625



## МУБИС-ИЙН ОЮУТНЫ ЖУРАМ


### НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1. МУБИС-ийн бакалаврын оюутан, магистрант, докторант (цаашид "оюутан" гэх) нь ёс зүйн харилцаа, сургалт, эрдэм шинжилгээний ажилд оролцох болон хөдөлмөр зуучлал, сургалтын тэтгэлэг, оюутны байр зэрэг төрөл бүрийн үйлчилгээ хүртэх үйл ажиллагаандаа энэхүү журмыг мөрдөнө.
- 1.2. Оюутанд үзүүлэх үйлчилгээний үндсэн зорилго нь тэдэнд сургалт, судалгааны ажил гүйцэтгэх, шинэ мэдээллийг амьдрал, практикт хэрэглэх боломж олгох, сорил, туршилт хийх арга зүйгээ гүнзгийрүүлэн дадлагажих, туршлага хуримтлуулах, мэргэжлийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, тэднийг урамшуулах чиглэлээр хөгжил, төлөвшлийг нь дэмжихэд чиглэнэ.
- 1.3. МУБИС нь оюутан бүрд Монгол Улсын холбогдох хуульд заасан суралцагчийн эрх, үүрэг, бусад дүрэм, журмын хэм хэмжээнд өөрийн удирдлагатай суралцахуйн үйл ажиллагаа явуулах, холбогдох үйлчилгээг бүрэн авах боломжийг тэгш, хүртээмжтэй, нээлттэй байлгах зарчмыг баримтална.

### ХОЁР. Оюутны мөрдөх зарчим

- 2.1. МУБИС-ийн алсын хараа болон эрхэм зорилго, үнэт зүйлийг эрхэмлэн дээдэлж, сургуулийн нэр хүндийг өндөрт өргөн, шилдэг багш, мэргэжилтэн болохын тулд авьяас, мэдлэг, чадвараа дайчлан суралцдаг байх;
- 2.2. Нийгмийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэдлэг эзэмших, харилцааны соёл, багаар ажиллах чадварт суралцах, бусад оюутнуудтай өөрийн мэдлэг, туршлагыг хуваалцах, мөн тэднээс суралцах, хамтран ажиллахыг эрхэмлэдэг байх;
- 2.3. Бүтээлчээр бие даан суралцах чадвар эзэмшихэд анхаарч, сурах мэдэхийн төлөө эрэл хайлт байнга хийдэг байх;
- 2.4. Сургалтын орчин, хичээлийн байр, номын сан, сургалт-эрдэм шинжилгээний лаборатори болон сургалтын бусад хэрэгслийг хөгжих, төлөвших үйл ажиллагаандаа бүтээлчээр ашиглаж, тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дагадаг байх;
- 2.5. Сургуулиас зохиож буй соёл, олон нийтийн ажилд идэвх санаачилгатай оролцож бусдыг манлайлдаг байх;
- 2.6. Багш шавийн харилцааг хүндэтгэн дээдэлдэг байх;
- 2.7. Оюутан нь өөрийн ялгаатай хэрэгцээг хэт давуу байдлаар ашиглахгүй байхын зэрэгцээ бусад оюутнуудын ялгаатай байдал, чадвар боломжийг хүндэтгэх, хүлээн зөвшөөрөх, үл ялгаварлах;
- 2.8. Ялгаатай хэрэгцээтэй оюутанд дэмжин туслах, хамтран суралцах, тэдэнд тулгарч буй саад бэрхшээл болон түүнийг шийдвэрлэх арга зам, боломжийн талаар өөрийн санал бодлыг холбогдох алба, мэргэжилтнүүдэд хүргэдэг байх;
- 2.9. Жендерийн эрх тэгш байдал, бүх оюутны нийгэм, соёлын нөхцөл байдлыг хүндэтгэх;

## ГУРАВ. Оюутны баримтлах ёс зүйн хэм хэмжээ



- 3.1. Оюутан нь Монгол Улсын хууль тогтоомж, сургуулийн дүрэм, сургалтын журам болон "суралцах гэрээ"-ээр хүлээсэн үүрэг, ёс зүйн хэм хэмжээг баримтлан сургуулийн дотоод дэг, журмыг чанд мөрдөх;
- 3.2. Бусдад хүндэтгэлтэй хандаж, ажил хэрэгч бодитой шүүмжлэл, саналыг хүлээн авч аливаа маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдэх;
- 3.3. Багш болон сургуулиас тавьсан зүй ёсны шаардлага, өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх;
- 3.4. Бусдын нэр төр, эрх чөлөөг эрхэмлэн хүндэтгэж, хувийн нууцыг хамгаалдаг, тэгш ханддаг байх;
- 3.5. Багш, ажилтан, ажилчдыг хүндлэх, зүй ёсны шаардлагыг биелүүлэх, хичээл, сургалтын үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцох, хичээлийн дэг, журмыг зөрчихгүй байх;
- 3.6. Сургалт, эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхдээ бусдын зохиол бүтээл, судалгааны ажил, нээлтийг хүндэтгэн үзэж эшлэл, зүүлт хийж, оюуны өмчийн хуулийг зөрчихгүй байх;
- 3.7. Бусдын санаа бодол, ухамсарт сайнаар нөлөөлөх ба үзэл бодлоо тулгах, зандрах, айлган сүрдүүлэх зэрэг үйлдэл хийхгүй байх;
- 3.8. Цахим орчинд соёлтой, ёс зүйтэй харилцааг эрхэмлэж, өөрийн болон бусдын цахим аюулгүй байдлыг хангаж оролцох;
- 3.9. Хичээл, шалгалтаас хоцрох, хүндэтгэн үзэх шалтгаангүй таслах, бие даалтын ажил гүйцэтгэхэд бусдын санааг хуулах, хууран мэхлэх, сурч мэдэхийн төлөө бие даан эрэл, хайлт үл хийх зэрэг сурах үйл явцдаа шударга бус аргуудыг хэрэглэхгүй байх;
- 3.10. Сургуулийн байр, сургалтын орчин, дотуур байранд согтууруулах ундаа, тамхи болон электрон тамхи, мансууруулах эм, бодис хадгалах, худалдах, хэрэглэхгүй байх;
- 3.11. Ёс зүйн зөрчил гаргасан оюутанд зөрчлийн хэр хэмжээ, нөхцөл байдлыг харгалзан МУБИС-ийн бүрэлдэхүүний сургууль нь сануулах, донгодох, учирсан хохирлыг төлүүлэх, сургуулиас чөлөөлөх хүртэл арга хэмжээ авч хариуцлага тооцох эрхтэй.
- 3.12. Ёс зүйн зөрчил гаргасан оюутны асуудлыг бүрэлдэхүүний сургуулийн оюутны зөвлөл, харьяа тэнхим хэлэлцэж, сануулах, хохирол төлүүлэх асуудлыг шийдэх ба сургуулиас чөлөөлөх тохиолдолд МУБИС-ийн Оюутны зөвлөлийн тэргүүн, тухайн сургуулийн Оюутны зөвлөлийн төлөөлөл оролцон, бүрэлдэхүүн сургуулийн захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 3.13. Сургууль, дотуур байрнаас хасагдах шийдвэр гарсан оюутанд сургалтын болон дотуур байрны төлбөрийг нь буцаан олгохгүй. Энэхүү журмын ёс зүйн зөрчилд заасан үйлдлүүдийг мэдээгүй байх нь хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

## **ДӨРӨВ. Оюутны эрх, үүрэг**

Оюутан дараах эрхтэй:

- 4.1. Эрүүл, аюулгүй, жендерийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах;
- 4.2. Уламжлалт соёл, зан заншлыг өвлөх, сургуулийн орчинд эх хэлээрээ харилцах, тогтвортой ирээдүйн төлөөх үйл ажиллагаанд оролцдог байх;
- 4.3. Чадамжаа үнэлүүлэх, хүлээн зөвшөөрүүлэх, дүйцүүлэх, баталгаажуулах;
- 4.4. Сургалтын төлбөр, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих;
- 4.5. Суралцагчийн өөрийн удирдлагын байгууллагаар дамжуулан боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд оролцох;
- 4.6. Сургалтын чанар, сургалтын хөтөлбөр, агуулгын талаар санал, хүсэлт илэрхийлэх, судалгаа, шинжилгээний ажилд оролцох;
- 4.7. Хүмүүнлэгийн болон сайн дурын үйл ажиллагааг санаачлах, оролцох;
- 4.8. Хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх, нийгмийн баталгаагаар хангагдах;
- 4.9. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагч нь бусад суралцагчийн адил боловсрол эзэмших тэгш боломж, нөхцөлөөр хангагдах;
- 4.10. Ялгаатай хэрэгцээнээс үл хамааран чанартай боловсрол эзэмших тэгш боломжоор хангагдах;
- 4.11. Албан ба албан бус сургалтад хамрагдах, эзэмшиж буй мэргэжлийн чиглэлээр өсөж хөгжих, арга зүйн зөвлөгөө, сургалтын тэтгэлэг авахад жендерийн тэгш эрхтэй;
- 4.12. Хуульд заасан бусад эрхийг эдэлнэ.

Оюутан дараах үүрэгтэй:

- 4.13. Эрүүл мэндийн даатгалд заавал хамрагдах;
- 4.14. Сургалтын хөтөлбөр, агуулгыг эзэмших;
- 4.15. Багш, ажилтны хууль ёсны шаардлага, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;
- 4.16. Багш, ажилтан, суралцагч, хамт олны харилцааг эрхэмлэх, бусдыг хүндэтгэх;
- 4.17. Боловсролын сургалтын байгууллагатай байгуулсан гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
- 4.18. Сургалтын төлбөрийг тогтоосон хугацаанд төлж сургуулийн үйл ажиллагаанд хүндрэл учруулахгүй байх;
- 4.19. Бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх;
- 4.20. Бусдын ялгаатай байдлыг хүлээн зөвшөөрч, хүний эрх, эрх чөлөөг дээдэлж, ялгаварлан гадуурхах, дарамтлах, доромжлох, нэр төр, алдар хүндийг нь гутаах үйлдэл гаргахгүй байх үүрэгтэй.

## **ТАВ. Оюутны суралцах үйл ажиллагаа**

- 5.1. Бүрэн дунд боловсрол эзэмшиж, элсэлтийн ерөнхий шалгалтын босго оноог давсан, эсвэл бүрэн дундаас дээш боловсролтой иргэн болон гадаад суралцагч МУБИС-ийн бакалавр, магистр, докторт элсэн суралцах боломжтой.



- 5.2. Элсэлт, суралцах үйл ажиллагаа, сонголт, үнэлгээ, шилжих, чөлөө авах, сургуулиас чөлөөлөгдөх асуудлыг МУБИС-ийн Элсэлтийн журам, Сургалтын журам, Ахисан түвшний сургалтын үйл ажиллагааны журам, Оюутныг үнэлэх журмаар тус тус зохицуулна.
- 5.3. Сургалтын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь танхимын сургалт байх бөгөөд сургалтыг мэдээллийн технологи ашиглан, хосолсон болон цахим хэлбэрээр зохион байгуулж болно.
- 5.4. Бакалаврын оюутны суралцах ердийн хугацаа 8 улирал байх бөгөөд өмнөх боловсролын зэрэг, хичээл дүйцүүлэлт, хичээлийн сонголт зэргээс шалтгаалан суралцах улирал өөр байж болно. Магистрын хөтөлбөрийн үндсэн хугацаа 3 улирал, докторын хөтөлбөрийн үндсэн хугацаа 6 улирал байх бөгөөд магистрант, докторантын сонгосон кредитээс шалтгаалан үүнээс олон байж болно.
- 5.5. Бакалаврын намар, хаврын үндсэн улирал тус бүр хичээл сонголтын 0 долоо хоног, танхимын хичээлийн 15 долоо хоног, улирлын төгсгөлд шалгалт авах, дүн баталгаажуулах долоо хоног буюу нийт 16 долоо хоног байна. Ахисан түвшний сургалт намар, хавар, өвөл+зун гэсэн 3 үндсэн улиралтай байна. Нэг улирлын үргэлжлэх хугацаа 16 долоо хоног байх бөгөөд үүнд үндсэн сургалт, бие даан суралцах, судалгааны ажил, семинар, хэлэлцүүлэг зэрэг багтана.
- 5.6. Сургалтын төлбөрийг МУБИС-ийн удирдах зөвлөлөөс тогтоож мөрдөх ба сургалтын хэлбэрээс шалтгаалж харилцан адилгүй байж болно.
- 5.7. Шилжиж ирсэн оюутан тухайн улирлын сургалтын төлбөрөөс гадна шилжин суралцах төлбөр төлнө. Оюутан нь бүрэлдэхүүний болон салбар сургууль хооронд шилжин суралцах бол төлбөр төлөхгүй, бусад их сургуулиас шилжин суралцах бол 4 кредиттэй тэнцэх төлбөр төлнө. (Төлбөрийг тухайн жилийн кредитийн суурь үнэлгээгээр тооцно.)
- 5.8. Хичээл сонголт нь дараагийн улиралд судлах хичээлээ захиалах болон хичээлийн хуваарь, багшаа сонгох гэсэн хоёр үе шаттай, цахим хэлбэрээр явагдана.
- 5.9. Бакалаврын оюутны үндсэн улиралд судлах кредит цагийн дээд хэмжээ 21, доод хэмжээ 10 байна. Магистрант, докторант нэг улиралд 15 хүртэл кредит судлах ба үүнд судалгааны ажлын кредит хамаарахгүй.
- 5.10. Бакалаврын оюутан тухайн хичээлд 61 ба түүнээс дээш оноо авсан бол уг хичээлийн агуулгыг судалж, кредитээ биелүүлсэн, харин 60 ба түүнээс доош оноо авсан бол "хангалтгүй" суралцсан буюу тухайн хичээлийн кредитийг биелүүлээгүй гэж тус тус үзнэ. Магистрант, докторант тухайн хичээлийг судалж, 71 (С-) ба түүнээс дээш оноо авсан бол тухайн кредит цагийг биелүүлсэнд тооцно.
- 5.11. Суралцагчийн хүсэлтийг үндэслэн, 30 хоногийн чөлөөг бүрэлдэхүүн болон салбар сургуулийн хөтөлбөрийн албаны дарга, улирлын, жилийн чөлөөг бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлын тушаалаар олгоно. Чөлөөг сунгах, дахин олгох хүсэлтийг бичгээр гаргана.
- 5.12. Чөлөөлөгдөх тухай хүсэлт гаргасан оюутныг төлбөрийн болон бусад тооцоогүйг илтгэх "Тойрох хуудас"-д үндэслэн, тухайн сургуулийн захирлын тушаалаар сургуулиас чөлөөлнө.

- 5.13. Оюутныг дараах шалтгаанаар сургуулиас хасна. Үүнд: Чөлөөний хугацаа дуусаад хичээлд бүртгүүлээгүй, чөлөө сунгах тухай хүсэлтээ ирүүлээгүй, 6-аас дээш улирал дараалан суралцаагүй, сургуультай байгуулсан гэрээ болон энэ журамд заасан хугацаанд сургалтын төлбөрөө төлөөгүй бол хөтөлбөрийн албанаас сургуулиас хасах тухай анхааруулга өгөх ба анхааруулсан хугацаанд төлбөр төлөөгүй бол, мөн эзэмшсэн мэдлэг, чадвараа үнэлүүлэхдээ хууран мэхлэх, дүнгийн тодорхойлолтыг хуурамчаар үйлдэх зэрэг зөрчил давтагдвал, гэмт хэрэг, ёс суртахууны ноцтой зөрчил гаргасан нь хууль, хяналтын байгууллагаар тогтоогдсон зэрэг орно.
- 5.14. Төгсөгч нь МУБИС-д зохих журмын дагуу захирлын тушаалаар элссэн, сургалтын төлөвлөгөөний дагуу суралцаж буй хөтөлбөрийнхөө заавал болон сонгон суралцах хичээлүүдийг амжилттай судалж, ахицын хангалттай үнэлгээ авсан, төгсөлтийн ажил бичиж хамгаалсан байхын зэрэгцээ холбогдох дүрэм журмын шаардлагуудыг биелүүлсэн байна.
- 5.15. Бакалавр, магистрын төгсөлтийг жилд хоёр удаа (өвөл, хавар), докторын зэрэг олгох төгсөлтийг улиралд 1 удаа тус тус зохион байгуулна.
- 5.16. Хөгжлийн ялгаатай оюутан суралцахад дараах дэмжлэг үзүүлнэ.
- 5.16.1. Шинээр элсэн суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагч өөрийн онцлог хэрэгцээ, шаардлагатай тусламж, дэмжлэг, үйлчилгээний талаар холбогдох албанд хүсэлт гаргаж, шийдвэрлүүлнэ.
- 5.16.2. Тэгш хамрагдахад учирч буй саад бэрхшээлийг шийдвэрлэхэд холбогдох мэргэжлийн бүлэг, байгууллага, олон нийттэй хамтран ажиллах боломжийн талаар болон өөрийн саналыг илэрхийлнэ.
- 5.16.3. Ялгаатай хэрэгцээтэй оюутан эрүүл мэнд болон бусад нөхцөл байдлын улмаас хичээлийг танхимаар судлах боломжгүй тохиолдолд цахимаар судлах хүсэлтээ харьяа сургуулийн хөтөлбөрийн албанд гаргаж шийдвэрлүүлэх, цахимаар суралцах тохиолдолд бүх оюутанд тавигдах шаардлагын дагуу үр дүнтэй, бүтээлчээр суралцана.
- 5.16.4. Тэгш хамран сургах, суралцахууд ээлтэй, хүртээмжтэй материаллаг орчин, хэрэглэгдэхүүнтэй холбоотой санал хүсэлтээ хөтөлбөрийн албаар дамжуулан багш нарт илэрхийлж, шийдвэрлүүлнэ.

### **ЗУРГАА. Оюутны эрдэм шинжилгээний ажлыг дэмжих**

А. Оюутны эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөх, зохион байгуулах талаар

- 6.1. Оюутны эрдэм шинжилгээний ажлын төлөвлөлт, зохицуулалтыг тэнхимүүд гүйцэтгэнэ.
- 6.2. Оюутны эрдэм шинжилгээний ажлыг төлөвлөж зохион байгуулахад “Суралцагчдад судалгааны тэтгэлэг олгох” журмыг мөрдлөг болгоно.
- 6.3. Бүрэлдэхүүний сургуулийн хэмжээнд гүйцэтгэх оюутны дипломын ажлын сэдвийг мэргэжлийн тэнхимүүд жил бүрийн 10 сарын эхний хагаст багтаан гаргаж, оюутнаар сонголт хийлгэнэ. Оюутны сонгосон сэдвээр судалгаа явуулах арга зүйг тухайн тэнхимийн хурлаар хэлэлцэж батална.
- 6.4. Оюутны эрдэм шинжилгээний ажлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:

- 
- 6.4.1. Сургуулиас гүйцэтгэж байгаа төсөл, суурь судалгааны ажил, гэрээт ажилд оролцуулах;
  - 6.4.2. Судалгаа шинжилгээний дугуйланд батлагдсан хөтөлбөрийн дагуу хичээллэх;
  - 6.4.3. Мэргэжлийн тэнхим, салбараас баталсан арга зүйн дагуу лабораторийн болон хээрийн туршилт гүйцэтгэх;
  - 6.4.4. Судалгааны ажлын үр дүнгээр МУБИС, мэргэжлийн болон олон нийтийн бусад байгууллагаас зарласан эрдэм шинжилгээний бага хуралд оролцож, илтгэл тавьж хэлэлцүүлэх;
  - 6.4.5. Төгсөлтийн ажлын хүрээнд туршилт, судалгааны ажил гүйцэтгэж хамгаалах;
  - 6.4.6. Мэргэжлийн тэнхим, нэгжээс баталсан сэдвээр шинжлэх ухааны мэдээлэл хайх, цуглуулах, боловсруулах, дүгнэлт хийх зэргээр гүйцэтгэх ажил орно.
- 6.5. Оюутны эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнг бүрэлдэхүүний сургуулийн эрдмийн зөвлөлөөр хэлэлцэж, тайланг эрдэм шинжилгээ, инновацын албанд ирүүлэн зохих шийдвэр гаргуулан ажиллана.

**Б. Эрдэм шинжилгээний ажлыг дүгнэх, шалгаруулах**

- 6.6. Бакалаврын оюутан болон магистрант, докторантын эрдэм шинжилгээний шилдэг илтгэл шалгаруулах ажлыг жил бүр эрдэм шинжилгээний бага хурлын хэлбэрээр 3 үе шаттай зохион байгуулна.
- 6.7. Оюутны эрдэм шинжилгээний анхан шатны бага хурлыг мэргэжлийн тэнхимүүд дээр, 2 дахь шатны бага хурлыг бүрэлдэхүүн болон салбар сургуулиуд жил бүрийн 3 дугаар сарын сүүлийн хагаст, МУБИС-ийн хэмжээний эрдэм шинжилгээний бага хурлыг жил бүрийн 4 дүгээр сарын эхний хагаст тус тус зохион байгуулна.
- 6.8. Эрдэм шинжилгээний хуралд шалгарч оролцсон оюутныг бүрэлдэхүүний болон их сургуулийн зүгээс тодорхойлж гадаад, дотоодын төрөл бүрийн тэтгэлгийн шаардлага хангасан бол тэргүүн ээлжинд хамруулна.

**ДОЛОО. Оюутанд чиглэсэн үйлчилгээ**

**7. МУБИС-ийн оюутан дараах үйлчилгээнүүдэд хамрагдах боломжтой.**

- 7.1. МУБИС-ийн Эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ
  - 7.1.1. Эрүүл мэндийн үзлэг, зөвлөгөө, анхан шатны тусламж авах;
  - 7.1.2. Өвчин эмгэг илэрсэн тохиолдолд дараагийн шатлалд шилжих тодорхойлолт, чиглүүлэг авах;
- 7.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
  - 7.2.1. Оюутан суралцагчдад чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн сургалтад хамрагдах;
  - 7.2.2. ДЭМБ-ын тэмдэглэлт өдрүүдээр зохион байгуулдаг үйл ажиллагаанд хамрагдах, мэдээлэл авах;

### 7.3. Сэтгэл зүйн үйлчилгээ

- 7.3.1. Шинээр элсэгчид сэтгэцийн хөгжлийн оношилгоо, үнэлгээнд хамрагдах;
- 7.3.2. МУБИС-ийн оюутнуудад зориулсан сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдах;
- 7.3.3. Сэтгэл зүйн боловсролоо дээшлүүлэх сургалт, вебинар, хэлэлцүүлэгт оролцох;

### 7.4. Оюутны байрны үйлчилгээ

- 7.4.1. Оюутны дотуур байраар үйлчлүүлэхэд МУБИС-ийн оюутны дотуур байрны журмыг мөрдлөг болгоно.
- 7.4.2. Оюутны дотуур байранд оршин суух хяналтын тоонд багтааж, бүрэлдэхүүний сургууль нэгжийн удирдлага, оюутны холбооны зөвшөөрөл олгосноор оюутны дотуур байранд оруулна.
- 7.4.3. Оюутан нь байрны төлбөрийг бүрэн төлж, байрны зохион байгуулагчтай гэрээ байгуулснаар дотуур байранд амьдрах эрхтэй болох бөгөөд дотуур байранд амьдарч байгаа оюутан нь байрны ариун цэвэр, гэрэлтүүлэг, дулаан зэрэг үйлчилгээний талаар санал, шүүмжлэлээ байрны захиргаанд гаргаж, биелэлтэд нь хяналт тавих эрхтэй.
- 7.4.4. Оюутан нь дотуур байр, нийтийн эзэмшлийн газарт архи уух, тамхи татах, хог хаях, хөгжим чанга тавих, орилж хашхирах, зорилгогүй сэлгүүцэх зэргээр бусдын амгалан тайван байдлыг алдагдуулан, зүй бус авир гаргахгүй байх үүрэгтэй ба үүргээ биелүүлэхгүй бол оюутны байранд үргэлжлүүлэн оршин суух эсэхийг гэрээний дагуу шийдвэрлэнэ.
- 7.4.5. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан дотуур байранд орох хүсэлтээ гаргасан тохиолдолд дугаар харгалзахгүйгээр оюутны байранд орох эрхтэй.
- 7.4.6. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан суралцагч оюутны байрны зохион байгуулагчид өөрийн онцлог хэрэгцээг илэрхийлж, орчны хүртээмжийг нэмэгдүүлэхэд өөрийн саналыг хэлж хамтран шийдвэрлэх боломжтой.

### 7.5. Номын сангийн үйлчилгээ

- 7.5.1. Номын сангийн үйлчилгээ авахад МУБИС-ийн номын сангийн үйлчилгээний журмыг мөрдлөг болгоно.
- 7.5.2. Төв болон бүрэлдэхүүний сургуулийн номын сангийн фонд, уншлагын танхим дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:
  - 7.5.2.1. Сан хөмрөгт хадгалагдаж буй ном хэвлэлийг зохих журмын дагуу уншигчдад ашиглуулах, электрон болон цаасан каталог, картын сан, цахим, онлайн мэдээллийн сангаар уншигчдад үйлчилгээ үзүүлэх;
  - 7.5.2.2. Номын эргэлтэд хяналт тавих, уншигчийн хугацаа хэтрүүлсэн номыг эргүүлэн татах;

### 7.6. Орлоготой оюутан хөтөлбөр

- 7.6.1. "Орлоготой оюутан" үндэсний хөтөлбөрийн хүрээнд оюутнууд өөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, бие хүний төлөвшил, хичээл сургалтын



үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхгүй байх нөхцөлийг хангасны үндсэн дээр цагийн ажил, хөдөлмөр эрхлэх эрх зүйн харилцаанд оролцох;

7.6.2. Оюутан өөрийн хүсэл, сонирхол, сонголт, хэрэгцээний дагуу хамрагдах;

7.6.3. Гэрээнд заасан тарифт цалин, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ цэнд тохирсон хөлс авах;

**7.7. Сайн дурын үйл ажиллагаа**

7.7.1. Оюутан нь бакалаврын сургалтын төлөвлөгөөн дэх сайн дурын үйл ажиллагааны 2 кредитийн агуулгыг судлахдаа МУБИС-ийн сайн дурын үйл ажиллагаа зохион байгуулах журмыг мөрдлөг болгоно.

7.7.2. Энэхүү үйл ажиллагаа нь сайн дурын, хууль ёсны, тэгш эрхийн зарчимд тулгуурлах бөгөөд үнэ төлбөргүй, улс төр, шашин, арилжааны зорилгогүй байна.

7.7.3. Сайн дурын үйл ажиллагааг эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамж, хамгаалал, хүрээлэн буй орчин, байгаль орчныг хамгаалах, хог хаягдал цэвэрлэх, мод зүлэг тарих, орчны тохижилт хийх зэрэг хүрээнд хэрэгжүүлнэ.

**НАЙМ. Оюутны урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлт**

**А. МУБИС-ийн ректорын нэрэмжит батламж ба тэтгэлэг**

8.1. Сургалтын нэгдсэн хуанлийн улирал бүрийн эхний долоо хоногт өмнөх улиралд сурлагын өндөр амжилт гарган суралцсан тэргүүний оюутанд "Ректорын нэрэмжит батламж"-ийг МУБИС-ийн ректорын тушаалаар олгоно.

8.2. "Ректорын нэрэмжит батламж"-ийг дараах болзлыг хангасан оюутанд олгоно. Үүнд:

8.2.1. Сургуулийн дүрэм, дотоод журам болон суралцах гэрээгээ зөрчөөгүй;

8.2.2. Нэг улиралд судалсан кредитийн тоо 15-аас дээш;

8.2.3. Улирлын үнэлгээний голч дүн 3.7 болон түүнээс дээш байна.

8.3. Батламжийг 3 улирал дараалан авсан оюутны тухайн жилийн сургалтын суурь төлбөрийн 20 хувиар хөнгөлнө.

8.4. Сургалтын нэгдсэн хуанлийн эхэнд сурлага, спорт, урлаг, хөдөлмөрийн өндөр амжилт гарган суралцсан тэргүүний оюутанд "МУБИС-ийн ректорын нэрэмжит тэтгэлэг" олгож, нийтэд сурталчилна.

8.5. "Ректорын нэрэмжит тэтгэлэг"-ийг дараах болзлыг хангасан оюутанд олгоно. Үүнд:

8.5.1. 4 ба түүнээс дээш улирал дараалан 3.7 болон түүнээс дээш голч дүнтэй суралцсан;

8.5.2. Сургуулийн дүрэм, дотоод журам болон суралцах гэрээгээ зөрчөөгүй;

8.5.3. Их, дээд сургуулиудын болон олон улсын оюутны эрдэм шинжилгээний бага хуралд оролцож байр эзэлсэн;

8.5.4. Урлаг, спортын чиглэлээр олон улс, улсын хэмжээнд онцгойлох амжилт гаргасан;

- 8.6. "Ректорын нэрэмжит тэтгэлэг"-ийг бүрэлдэхүүний сургуулийн захирлын тодорхойлолтыг үндэслэн, хичээлийн жилд нэг удаа МУБИС-ийн хэмжээнд 10 хүртэл оюутанд олгоно.
- 8.7. Тэтгэлгийн хэмжээ нь тухайн жилийн оюутны сургалтын суурь төлбөрийн 50 хувьтай тэнцэх хэмжээтэй байх ба түүнийг батламж дагалдана.
- 8.8. Спорт тоглоомын төрлөөр олон улсын тэмцээнд шагналт байрт шалгарсан, улсын аварга шалгаруулах тэмцээнд эхний гурван байр эзэлсэн спортын өндөр ур чадвартай 5 хүртэлх суралцагчдад "МУБИС-ийн ректорын нэрэмжит" сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг олгоно. Тэтгэлэгт хамрагдсан оюутантай нэг жилийн захирлын тушаалаар баталгаажуулан гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг дүгнэн, гэрээг үргэлжлүүлэн сунгах, тэтгэлгийн хувь хэмжээг бууруулах эсэхийг шийдвэрлэнэ.
- 8.9. Хөгжлийн бэрхшээлтэй оюутан нь төрөөс үзүүлж буй хөнгөлөлт, тэтгэлгийн шаардлагыг ханган суралцаагүй буюу оюутны голч оноо 2.8-аас доош тохиолдолд тэтгэлгийг цуцална. Энэ тохиолдолд сургалтын төлбөрийг оюутан өөрөө төлж, үргэлжлүүлэн суралцана.

#### Б. МУБИС-ийн шилдэг оюутан

- 8.10. Олон улс болон үндэсний хэмжээнд сургалт, эрдэм шинжилгээ, урлаг, спортын онцгой амжилт гаргасан 3 хүртэлх оюутанд "МУБИС-ийн ректорын нэрэмжит" сургалтын төлбөрийн 100 хувийн тэтгэлэг олгоно.
- 8.11. МУБИС-ийн нэрийн өмнөөс олон улс, улс, бүс нутаг, их дээд сургуулиудын дунд зохиогдож байгаа эрдэм шинжилгээний хурал, олимпиад, спорт, урлагийн уралдаан тэмцээн, наадмуудад холбогдох нэгж, сургууль, захирлын зөвшөөрлийн дагуу амжилттай оролцож эхний гурван байрт шалгарсан, оюутнуудын сайн дурын болон мэргэжлийн клубийн үйл ажиллагаанд оролцсон байдлыг тусгай удирдамжийн дагуу үнэлэн МУБИС-ийн шилдэг оюутнаар өргөмжлөн урамшуулна. Энэхүү урамшууллыг тэмцээн, уралдааны нэр төрлийг давхцуулан олгохгүй.
- 8.12. МУБИС-ийн шилдэг оюутныг хичээлийн жил бүр бүрэлдэхүүний сургуулиудаас ирүүлсэн тодорхойлолтыг үндэслэн шалгаруулна.
- 8.13. Бүрэлдэхүүний болон салбар сургууль бүр сурлагын өндөр амжилт гаргасан, мөн олон улс, улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд онцгой амжилт гаргасан оюутныг шилдэг оюутанд өргөмжилнө.

#### В. Оюутанд олгох кредитийн тэтгэлэг

- 8.14. МУБИС-ийн болон бүрэлдэхүүний сургуулийн шилдэг оюутанд олгох тэтгэлгийн хэмжээг кредитээр тогтоож, түүнтэй тэнцэх хэмжээгээр төлбөрөөс чөлөөлөх урамшууллыг кредитийн тэтгэлэг гэнэ. Уг тэтгэлэг нь тухайн жилийн кредитийн суурь үнэлгээгээр тооцогдоно.
- 8.15. Эрдэм шинжилгээний хурал, олимпиадад эхний 3 байрт шалгарсан оюутанд кредитийн дараах тэтгэлэг олгоно. Үүнд:
- 8.15.1. МУБИС-ийн эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 1 хүртэл кредит;
- 8.15.2. Үндэсний хэмжээний эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 2

хүртэл кредит;

- 8.15.3. Олон улсын эрдэм шинжилгээний хурал, чуулган, олимпиад 3 хүртэл кредит;
- 8.16. Мэргэжлийн уралдаан, тэмцээнд оролцож, эхний 3 байрт шалгарсан оюутанд кредитийн дараах тэтгэлэг олгоно. Үүнд:
- 8.16.1. МУБИС-ийн хэмжээний уралдаан тэмцээн 1 хүртэл кредит;
- 8.16.2. Үндэсний хэмжээний уралдаан тэмцээн 2 хүртэл кредит;
- 8.16.3. Олон улсын хэмжээний уралдаан, тэмцээн 3 хүртэл кредит;
- 8.17. Урлаг, спорт, техник, технологийн уралдаан, тэмцээнд оролцож эхний 3 байрт шалгарсан оюутанд дараах кредитийн тэтгэлэг олгоно. Үүнд:
- 8.17.1. Үндэсний хэмжээний сургуулийн уралдаан, тэмцээн 1 хүртэл кредит;
- 8.17.2. Улсын чанартай уралдаан, тэмцээн 2 хүртэл кредит;
- 8.17.3. Олон улсын хэмжээний тэмцээн 3 хүртэл кредит;
- 8.18. МУБИС-ийн сайн дурын болон мэргэжлийн клубийн үйл ажиллагааг дэмжих үүднээс үр дүнтэй ажил тогтмол зохион байгуулж, сургуулийн нэгдсэн арга хэмжээнд идэвх зүтгэлтэй оролцдог оюутны клубийн ахлагчид ажлын үр дүнг нь харгалзан, жилд нэг удаа сургалтын төлбөр 2 хүртэлх кредитийн хөнгөлөлт үзүүлнэ.
- 8.19. МУБИС-ийн болон бүрэлдэхүүний сургуулийн хамт олны дунд нэр хүндтэй, шилдэг оюутанд тухайн сургуулийн захирлын нэрэмжит кредитийн урамшууллыг давхардуулахгүйгээр олгоно. Үүнд бүрэлдэхүүний сургуулиуд нь улирлын үнэлгээний голч дүнгийн доод хязгаарыг оюутны сурлагын амжилтаас хамааруулан дээшлүүлэн тогтоож болно. Үүнд:
- 8.19.1. 2 улирал дараалан 3.7-оос дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан бол 2 кредит;
- 8.19.2. 3 улирал дараалан 3.7-оос дээш үнэлгээний голч дүнтэй суралцсан бол 3 кредит байна.
- 8.20. МУБИС-ийн Оюутны холбоо, оюутны зөвлөл, оюутны байрны зөвлөлийн нэр дурдсан гишүүдэд ажлын үр дүнгээс хамааруулан улиралд нэг удаа, сургалтын төлбөрөөс нь хөнгөлж, кредитийн урамшуулал олгоно. Үүнд:
- 8.20.1. Оюутны холбооны тэргүүн, дэд тэргүүн, ерөнхий нарийн бичгийн даргад 2 хүртэл кредит;
- 8.20.2. Бүрэлдэхүүний сургуулийн оюутны зөвлөлийн даргад 1 хүртэл кредит;
- 8.20.3. Бүрэлдэхүүний сургуулийн оюутны зөвлөлийн дэд дарга, нарийн бичгийн дарга, оюутны байрны зөвлөлийн даргад 1 хүртэл кредит;
- 8.21. 8.20-д заасан урамшууллыг дараах байдлаар олгоно. Үүнд:
- 8.21.1. МУБИС-ийн Оюутны холбооны тэргүүний урамшууллыг оюутны хөгжил хариуцсан нэгжийн тодорхойлолтыг үндэслэн Сургалт, хамтын ажиллагааны газрын дарга баталгаажуулснаар улиралд 1 удаа олгоно.
- 8.21.2. Оюутны холбооны дэд тэргүүн, ерөнхий нарийн бичгийн даргын урамшууллыг оюутны холбооны тэргүүн болон оюутны хөгжил хариуцсан нэгжийн тодорхойлолтыг үндэслэн Сургалт, хамтын ажиллагааны газрын дарга баталгаажуулснаар улиралд 1 удаа олгоно.
- 8.21.3. Бүрэлдэхүүний сургуулийн оюутны зөвлөлийн дарга, дэд дарга, нарийн бичгийн дарга нарын урамшууллыг оюутны холбооны тэргүүний

тодорхойлолтыг үндэслэн, бүрэлдэхүүн болон салбар сургуулийн хөтөлбөрийн албаны дарга хянаж, захирал баталгаажуулснаар улиралд 1 удаа олгоно.

8.21.4. Оюутны байрны зөвлөлийн даргын урамшууллыг оюутны холбооны тэргүүний тодорхойлолтыг үндэслэн, тухайн байрны зохион байгуулагч хянаж, холбогдох сургуулийн захирал баталгаажуулснаар улиралд 1 удаа олгоно.

8.22. Голч оноо 3.8-аас дээш МУБИС-ийн төгсөгчдөд ахисан түвшинд суралцахад сургалтын төлбөрийн 20%-ийн тэтгэлэг олгоно.

### **ЕС. Оюутны байгууллага**

- 9.1. МУБИС-ийн Оюутны холбоо (МУБИСОХ) нь оюутнуудыг сайн дурын үндсэн дээр эгнээндээ нэгтгэсэн, тэдний эрх ашгийг төлөөлөн хамгаалах, үйлчлэх зорилго бүхий төр захиргааны байгууллагаас хараат бус, ашгийн бус байгууллага байна.
- 9.2. МУБИСОХ нь Монгол Улсын Үндсэн хууль, МУБИС-ийн дүрэм, Төрийн бус байгууллагын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 9.3. МУБИСОХ нь өөрийн бүрэлдэхүүний сургуулийн оюутны зөвлөл, Клубүүдийн зөвлөл, Оюутны байрны нэгдсэн зөвлөл зэрэг бүтэцтэй байна.

#### **А. Оюутны холбооны үндсэн чиг үүрэг**

- 9.4. Оюутан залуусын дунд эрдэм шинжилгээ, сургалт судалгаа, урлаг спорт, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих нийгмийн олон талт арга хэмжээ зохион байгуулах;
- 9.5. Оюутнуудын талаар төрөөс болон МУБИС-аас баримтлах бодлогыг тодорхойлон боловсруулахад оролцох, хэрэгжүүлэх;
- 9.6. Оюутан залуучуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх зорилгоор мэргэжлийн болон сонирхлын клуб дугуйлан ажиллуулах;
- 9.7. Монголын оюутны хөдөлгөөний эв нэгдлийг хамгаалах, оюутны байгууллагын хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх, мэдээлэл, санал бодлоо солилцох, илэрхийлэх бололцоог бүрдүүлэх;
- 9.8. Ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг гадаад, дотоодын байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудтай ажил төрлийн хамтын ажиллагааг бэхжүүлэх, хамтран төсөл хэрэгжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулах;
- 9.9. МУБИСОХ-ны хэтийн төлөвлөгөө, үйл ажиллагаагаараа өөрийн хөгжил, тогтвортой ажиллах баталгааг хангах, эдийн засаг, санхүүгийн боломжийг дээшлүүлэх, нийгэмд өрсөлдөх чадавхыг бэхжүүлэх;
- 9.10. МУБИСОХ нь хичээлийн жилийн эхэнд үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, хичээлийн жилийн эцэст тайлангаа оюутнуудад өдөрлөг хэлбэрээр танилцуулдаг байх;

#### **Б. Клубийн үйл ажиллагаа**

- 9.11. МУБИС-ийн Клубүүдийн зөвлөл нь мэргэжлийн болон сайн дурын клубийн үйл




- ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангана.
- 9.12. МУБИСОХ-ны дэргэд байгуулагдсан аливаа клуб нь оюутнуудын хувь хүний болон суралцаж буй мэргэжлийн чиглэлээрээ хөгжихөд нь нийцсэн олон талт үйл ажиллагаа явуулдаг байна.
- 9.13. Хичээлийн жилийн эхэнд үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, тухайн бүрэлдэхүүн болон салбар сургуулийн хөтөлбөрийн албаны даргаар батлуулна. Хичээлийн жилийн эцэст төлөвлөгөөний биелэлтийг Клубүүдийн зөвлөлд тайлагнана.

### **АРАВ. Гадаадын иргэнийг суралцуулах тухай**

- 10.1. Элсэн суралцах
- 10.1.1. Гадаадын иргэнийг оюутнаар элсүүлэн суралцуулах үйл ажиллагааг Монгол Улсын Дээд боловсролын тухай хуульд нийцүүлэн, МУБИС-д оюутан элсүүлэх журам, МУБИС-ийн сургалтын журмаар тус тус зохицуулна.
- 10.1.2. Гадаадын иргэн элсэлтийн бичиг баримтыг шаардлагын дагуу бүрдүүлж, монгол хэлний түвшин тогтоох шалгалтад 70%-аас доошгүй үнэлгээ авснаар элсэнэ.
- 10.1.3. Гадаадын элсэгч “МУБИС-д суралцах гэрээ”-г бүрэлдэхүүний сургуулийн захиралтай байгуулж, сургалтын төлбөр төлсөн баримтыг үндэслэн бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн албаны мэргэжилтний тусламжтайгаар СУМС-д хичээл сонголт хийнэ.
- 10.1.4. Суралцагч сонгосон хичээлийн хуваарийн дагуу мэргэжлийн тэнхимд хичээл судалж, зохих кредит цуглуулсан байна.
- 10.1.5. Суралцагч СУМС-ээс QR код бүхий оюутны хуудас, эсвэл бүрэлдэхүүн болон салбар сургуулийн хөтөлбөрийн албанаас оюутны үнэмлэх авснаар МУБИС-ийн оюутны бүх төрлийн үйлчилгээнд хамрагдах эрхтэй болно.
- 10.1.6. Бүрэлдэхүүний сургуулийн хөтөлбөрийн алба нь гадаад оюутны элсэлт, шилжилт хөдөлгөөн болон сургуулиас чөлөөлөгдөх тушаал гаргаж, Сургалт хамтын ажиллагааны газарт хүргүүлнэ.
- 10.2. Виз, оршин суух зөвшөөрөл
- 10.2.1. Суралцагч E2 ангиллын визний урилга сургуулиас авахдаа шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж, Гадаад харилцааны албанд хүргүүлнэ.
- 10.2.2. Суралцагч Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш 48 цагийн дотор гадаад оюутны бүртгэлийн маягт бөглөж, хүчинтэй визний хуулбар болон бусад бичиг баримтыг бүрдүүлж Гадаад харилцааны албанд бүртгүүлнэ.
- 10.2.3. Суралцагч оршин суух үнэмлэх авахдаа Монгол Улсын хилээр нэвтэрснээс хойш 21 хоногийн дотор шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж Гадаад харилцааны албанд хүргүүлнэ.
- 10.2.4. Суралцагч Монгол Улсад оршин суух визний зөвшөөрөлтэй холбоотой гарах зардлыг өөрөө хариуцна.
- 10.2.5. Суралцагч нэг хичээлийн жилд 2 удаа буюу өвөл, зуны амралтаар

өөрийн нутагтаа харих эрхтэй ба үүнээс бусад гэнэтийн болон ар гэрийн гачигдал, судалгаа хийх зорилгоор сургалтын дундуур тодорхой шалтгааны улмаас нутаг буцахаар болбол суралцагч нь чөлөө олгохыг хүссэн өргөдөл, чөлөө олгохыг зөвшөөрсөн хөтөлбөрийн албаны даргын гарын үсэг бүхий албан бичгийг авчирна.



#### 10.3. Суралцагчийг шилжүүлэх, чөлөөлөх

10.3.1. Суралцагч өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдөх, бусад сургуульд шилжин суралцах бол МУБИС-ийн ректорын тушаалаар шийдвэрлэж, Гадаадын иргэн харьяатын газраас олгосон оршин суух зөвшөөрлийг цуцлуулна. Түүнтэй холбогдон гарах зардлыг суралцагч өөрөө хариуцна.

10.3.2. Суралцагч өөрийн хүсэлтээр сургуулиас чөлөөлөгдвөл зохих журмын дагуу суралцаагүй хугацааны үлдсэн сургалтын төлбөрийг буцааж олгоно.

#### 10.4. Төгсөлт

10.4.1. Тус сургуулийн холбогдох сургалтын төлөвлөгөөний дагуу суралцаж, суралцагчдыг үнэлэх шаардлагыг ханган сургууль дүүргэсэн гадаадын иргэнд төгсөлтийн дипломыг, судалсан кредит цагийг илтгэсэн хавсралтын хамт англи, монгол хэл дээр үйлдэж олгоно.

10.4.2. Суралцагч төгссөн тохиолдолд оршин суух үнэмлэхээ Гадаад харилцааны албанд хураалган, албан бичиг авч хилээр гарах бөгөөд хэрвээ оршин суух үнэмлэхээ хилээр авч гарсан тохиолдолд холбогдох хууль дүрмийн дагуу хариуцлага хүлээнэ.

10.4.3. Суралцагчийн кредитийн тооцоо, үнэлгээ, дипломын дүнг нэгтгэн гаргах ажлыг бүрэлдэхүүний сургууль, тэнхим хариуцна.

### **АРВАН НЭГ. Журмын хэрэгжилт, үнэлгээ, сайжруулалт**

11.1. Энэхүү журамд батлагдсан эхний жилд нэг удаа, түүнээс хойш 2 жил тутамд хэрэгжилтийн үнэлгээ хийж, тайланг ректоратын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ. Шаардлагатай бол нэмэлт өөрчлөлт оруулж болно.

|   |                          |                                                                                                                                                                                                  |
|---|--------------------------|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | Сүүлд батлагдсан он      | 2018.12.24-ний өдрийн А/333 тоот захирлын тушаал                                                                                                                                                 |
| 2 | Нэмэлт өөрчлөлт          | <i>Шинээр нэмсэн: 59 заалт</i>                                                                                                                                                                   |
|   |                          | <i>Хассан: 43 заалт</i>                                                                                                                                                                          |
|   |                          | <i>Өөрчлөн найруулсан: 20 заалтыг шинэчлэн найруулсан.</i>                                                                                                                                       |
| 3 | Үйлчлэх хүрээ, зориулалт | Оюутанд үзүүлэх үйлчилгээний үндсэн зорилго нь тэдэнд сургалт, судалгааны ажил гүйцэтгэх, шинэ мэдээллийг амьдрал, практикт хэрэглэх боломж олгох, сорил, туршилт хийх арга зүйгээ гүнзгийрүүлэн |

|   |         |                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                 |
|---|---------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|   |         | <p>дадлагажих, туршлага хуримтлуулах, мэргэжлийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх, тэднийг урамшуулах чиглэлээр хөгжил, төлөвшлийг нь дэмжихэд чиглэнэ.</p>                                                                                                                                                                                                                                                                                                                                                                                          |
| 4 | Агуулга | <p>Нэг. Нийтлэг үндэслэл<br/>         Хоёр. Оюутны мөрдөх зарчим<br/>         Гурав. Оюутны баримтлах ёс зүйн хэм хэмжээ<br/>         Дөрөв. Оюутны эрх, үүрэг<br/>         Тав.Оюутны суралцах үйл ажиллагаа<br/>         Зургаа. Оюутны эрдэм шинжилгээний ажлыг дэмжих<br/>         Долоо. Оюутанд чиглэсэн үйлчилгээ<br/>         Найм.Оюутны урамшуулал, тэтгэлэг, хөнгөлөлт<br/>         Ес. Оюутны байгууллага<br/>         Арав. Гадаадын иргэнийг суралцуулах тухай<br/>         Арван нэг. Журмын хэрэгжилт, үнэлгээ, сайжруулалт</p> |

**МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬД****СУРАЛЦАХ ОЮУТНЫ ГЭРЭЭ (бакалавр)**

Энэхүү гэрээг нэг талаас Монгол Улсын Боловсролын Их Сургууль /цаашид МУБИС гэнэ/-ийг төлөөлж бүрэлдэхүүний сургуулийн захирал \_\_\_\_\_, нөгөө талаас суралцагч /цаашид суралцагч гэнэ/ -ийг төлөөлж \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ нь \_\_\_\_\_ оноос эхлэн ..... жилийн хугацаагаар суралцахаар тохиролцож, Монгол Улсын Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.6, БШУ-ы Сайдын ..... дугаар тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам", БШУ-ы Сайдын ..... оны "Босго оноо тогтоох тухай" ..... дугаар тушаал, "МУБИС-ийн дүрэм"-ийн 4.4.1, "Сургалтын журам"-ын 4.1 дэх заалт, МУБИС-ийн сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл бусад холбогдох эрх зүйн баримт бичгүүд болон МУБИС-ийн дүрэм, журмыг үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

**НЭГ. ЕРӨНХИЙ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү гэрээ нь Монгол Улсын болон гадаадын иргэнийг яс үндэс, гарал угсаа, хүйс, шашин шүтлэг, нийгмийн байдлыг харгалзахгүйгээр зохих хууль тогтоомж, дүрэм журмын дагуу элсүүлэх, сургуулийн болон сургалтын үйл ажиллагаатай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Элсэлтийн ерөнхий шалгалтыг амжилттай өгч, элсэх эрх авсан, тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн суурь төлбөр болон бусад шаардлагатай хураамж төлсөн суралцагчтай МУБИС-д элсүүлэн суралцуулах тухай захирлын тушаалыг үндэслэн энэхүү гэрээг байгуулна.
- 1.3. Энэхүү гэрээгээр бүрэлдэхүүний сургууль, суралцагч хоорондын харилцаа, тэдний эрх, үүргийг зохицуулна.
- 1.4. Гэрээний үйлчлэх хугацаа нь энэхүү гэрээнд заасан хугацаагаар тодорхойлогдох бөгөөд хүчин төгөлдөр байх хугацааг тухайн суралцагч анги дэвших бүрд сунгалт хийснээр баталгаажуулна.

**ХОЁР. МУБИС-ИЙН ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ**

- 2.1. Суралцагчийг сурч боловсрох нөхцөлөөр хангана.
- 2.2. Элссэн мэргэжлийн боловсролын хөтөлбөрөөр шаардлагатай мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх туршлагатай багш нараар сургалтыг зохион байгуулна.
- 2.3. Сургалт явуулах байр, танхим, мэргэжлийн онцлогт тохирсон сурах бичиг, гарын авлага, техник хэрэгсэл, номын сан болон мэдээллийн төвөөр үйлчилнэ.
- 2.4. Оюутны хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрийг санал болгоно.
- 2.5. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийн заавал болон сонгон судлах хичээлүүдийг амжилттай судалж, 120-оос доошгүй кредит цуглуулсан, ахицын шалгалтаар хангалттай үнэлгээ авсан, мэргэжлийн тэнхимээс, холбогдох



- дүрэм, журмын хүрээнд тавьсан тусгай шаардлагуудыг биелүүлсэн, 1.7-оос доошгүй голч оноотой суралцагчид МУБИС-ийн бакалаврын зэрэг олгоно.
- 2.6. Судалбал зохих хичээлийг бүрэн судалсан ч суралцсан хугацааны голч дүн 1.7-оос доогуур, эсвэл нэгдсэн (ахицын) үнэлгээг хангалттай өгч чадаагүй оюутанд дахин судлах буюу дээрх нөхцөлийг хангах боломж олгоно.
- 2.7. Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 364 дугаар тогтоол “Дээд боловсролын сургалтын байгууллагын суралцагчид төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх журам”-ын дагуу Боловсролын зээлийн сантай байгуулсан гэрээний дагуу элсэлтийн ерөнхий шалгалтад 650-аас 750 оноо авсан бол сургалтын төлбөрийн 70%-ийг, 751 болон түүнээс дээш оноо авсан бол 100% сургалтын төлбөрөөс тус тус чөлөөлнө.
- 2.8 Төрөөс үзүүлэх буцалтгүй тусламж, санхүүгийн дэмжлэгт суралцагчид хамрагдах бөгөөд тэтгэлгийн материал, Боловсролын зээлийн сангийн батлагдсан дүрэм, журмын хүрээнд тавьсан шаардлагуудыг хангасан байна. Үүнд:
- Бүтэн өнчин суралцагч;
  - Бакалавр, магистр, докторын хөтөлбөрт суралцагч хөгжлийн бэрхшээлтэй иргэн эсхүл, эцэг, эх нь хоеулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрт суралцагч;
  - Хөдөлмөрийн чадвараа алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч;
  - Цаатан өрхийн бакалаврын хөтөлбөрт суралцагч;
  - Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж байгаа гадаадын иргэн;
  - Нэг гэр бүлийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын хөтөлбөрт зэрэг суралцаж байгаа тохиолдолд нэг суралцагч.
  - Суралцагчид олгох суралцагчийн тэтгэлэг, хуулиар тогтоосон бусад санхүүгийн дэмжлэгийг дор дурдсан шаардлага хангасан болон суралцагчийн өмнөх улирлын голч дүн 2.8 болон түүнээс дээш үнэлэгдсэн тохиолдолд олгоно.
- 2.9. Монгол Улсын Засгийн газрын өндөр онооны тэтгэлэгт багш бус дараах мэргэжлээр суралцагчдад хамаарахгүй.
- Программ хангамжийн инженер
  - Экологи
  - Аялал жуулчлал /түүх, аялал жуулчлал/
  - Хэл, уран зохиол
  - Спортын дасгалжуулагч
  - Аялал жуулчлал /спорт/
  - Сэтгэл судлал, сургуулийн сэтгэл зүйч
  - Хувцасны дизайн
  - Боловсрол судлал
  - Нийгмийн ажил
  - Сэтгэл судлал
  - График дизайн
  - Сэтгүүл зүй
  - Архив судлал

- Нийгмийн ажил, хүүхдийн арга зүй

2.10. Засгийн газрын 70%, 100%-ийн өндөр онооны тэтгэлгээр суралцах болзол хангасан элсэгч тухайн хичээлийн жилийн сургалтын төлбөрийн хөнгөлөгдсөн хувийн зөрүү төлбөрийг төлнө.

*МУБИС-ийн тэтгэлэг, тэтгэмж:*

2.11. ЭЕШ-ын .....-аас дээш оноотой эрэгтэй элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 70%-ийн тэтгэлэг олгоно.

2.12. ЭЕШ-ын .....-аас дээш оноотой элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 50%-ийн тэтгэлэг олгоно. /МУБИС-ийн 2023 оны Элсэлтийн журамд буй мэргэжлүүд/

2.13. ЭЕШ-ын .....-аас дээш оноотой дараах хөтөлбөрөөр элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 50%-ийн тэтгэлэг олгоно. Үүнд:

- |                                           |                        |
|-------------------------------------------|------------------------|
| - Математикийн багш                       | - Физикийн багш        |
| - Мэдээлэл зүйн багш                      | - Биологийн багш       |
| - Дүрслэх урлагийн багш                   | - Бага ангийн багш     |
| - Дизайн зураг зүйн багш                  | - Газар зүйн багш      |
| - Дизайн технологийн багш                 | - Химийн багш          |
| - Сургуулийн өмнөх насны боловсролын багш | - Орос хэлний багш     |
| - Насан туршийн боловсролын багш          | - Солонгос хэлний багш |
| - Тусгай хэрэгцээт боловсролын багш       | - Биеийн тамирын багш  |
| - Герман хэлний багш                      | - Япон хэлний багш     |
| - Эрүүл мэндийн багш                      |                        |

2.14 Монгол Улсын Засгийн газрын өндөр онооны тэтгэлэгт багш бус мэргэжил хамаарахгүй. Үүнд:

- Программ хангамж
- Экологи
- Аялал жуулчлал /түүх, аялал жуулчлал/
- Хэл, уран зохиол
- Спортын дасгалжуулагч
- Аялал жуулчлал /спорт/
- Сэтгэл судлал, сургуулийн сэтгэл зүйч
- Хувцасны дизайн
- Боловсрол судлал
- Нийгмийн ажил
- Сэтгэл судлал
- График дизайн
- Сэтгүүл зүй
- Архив судлал
- Нийгмийн ажил, хүүхдийн арга зүйч

2.15 Монгол Улсын Засгийн газрын 321 тоот тогтоолоор Архангайн багшийн сургууль, Баян-Өлгийн багшийн сургуулийн сургалтын төлбөрийг төрөөс 4 жил 50 хувийн хөнгөлөлтөд хамруулна.

2.16 Сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон бусад байгууллага, хувь хүмүүсээс

- олгох тэтгэлэг, урамшуулал, тусламж, хөнгөлөлтөд хамруулах ажлыг зохион байгуулна.
- 2.17. Сургуулийн захиргаанаас оюутнуудыг сургуулийн дүрэм, журмыг чанд мөрдөхийг шаардах бөгөөд сургалт хүмүүжлийн ажлын шаардлага хангахгүй тохиолдолд зохих журмын дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 2.18. МУБИС-ийн бакалаврын голч оноо 3.8-аас дээш төгсөгчдөд МУБИС-ийн магистрын сургалтын төлбөрийн 20%-ийн тэтгэлэг олгоно.
- 2.19. МУБИС-ийн магистрын голч оноо 3.8-аас дээш төгсөгчдөд МУБИС-ийн докторын сургалтын төлбөрийн 20%-ийн тэтгэлэг олгоно.
- 2.20 Засгийн газрын болон МУБИС-ийн тэтгэлэг, тэтгэмжийг элсэгчдэд давхцуулан олгохгүй болно.
- 2.21. "МУБИС-ийн Сургалтын журам"-ын 4.9.6-д заасан шалтгаанаар сургуулиас хасах ба энэ тохиолдолд төлбөрийг буцаан олгохгүй.
- 2.22. МУБИС-ийн ЭЕШ-ын онооны тэтгэлэгт хамрагдсан элсэгчийн сургалтын төлбөрийн хөнгөлөгдсөн хувь зөрүү төлбөрийг төлүүлнэ.

### **ГУРАВ. ОЮУТНЫ ХҮЛЭЭХ ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Сургалтын байр, танхим, номын сан, мэргэжлийн онцлогт тохирсон сурах бичиг, гарын авлага, техник хэрэгслээр үйлчлүүлэх эрхтэй.
- 3.2. Сургуулиас гаргасан хичээл, шалгалтын болон бусад хуваарийг дагаж мөрдөнө.
- 3.3. Оюутнууд оюутны хөгжил, төлөвшилд чиглэсэн үйл ажиллагаа, хөтөлбөрт хамрагдах эрхтэй.
- 3.4. Хичээлийн жилийн турш 2.8-аас дээш голч дүнтэй суралцсан суралцагч тэтгэлэгт үргэлжлүүлэн хамрагдана.
- 3.7. МУБИС-ийн тэтгэлэгт хамрагдсан оюутан хүндэтгэх шалтгаангүйгээр сургуулиас гарах, өөр сургуульд шилжин суралцах тохиолдолд эхний жилийн сургалтын төлбөрийн ЭЕШ-ын 580-аас дээш оноотой эрэгтэй элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 70%-ийн тэтгэлэг, ЭЕШ-ын 580-аас дээш оноотой элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 50%-ийн тэтгэлэг, ЭЕШ-ын 550-аас дээш оноотой тодорхой хөтөлбөрөөр элсэгчдэд эхний жилд сургалтын төлбөрийн 50%-ийн тэтгэлгүүдийг буцаан төлнө.
- 3.8. МУБИС нь оюутан элсүүлэхдээ БШУ-ы Сайдын ..... дугаар тушаалаар батлагдсан "Оюутан элсүүлэх журам"-ыг баримтлан ур чадварын оноо шаардагдах хөтөлбөрийн ур чадварын оноог ЭЕШ-ын хоёр дахь хичээлд дүйцүүлэн тооцно.
- 3.9. Авьяас, ур чадвар шаардах багш, дизайн технологийн, багш-дүрслэх урлаг, багш зураг зүй дизайны, компьютер-график дизайн, багш биеийн тамир, спортын дасгалжуулагч, багш урлагийн боловсрол, хувцас дизайн, багш, мэдээлэл зүйн боловсрол, багш, насан туршийн боловсрол, багш, тусгай хэрэгцээт боловсрол, багш, бага ангийн боловсрол, багш, сургуулийн өмнөх насны боловсрол зэрэг хөтөлбөрөөр элсэх бол ерөнхий шалгалтаас гадна ур чадварын шалгалт өгнө. Ур чадварын шалгалтыг Улаанбаатар хотод МУБИС-ийн Элсэлтийн төв комисс, аймаг орон нутагт МУБИС-аас томилсон комисс авна.
- 3.10. Ур чадварын шалгалтын дээд оноо 800 байх ба шалгалтад анхны онооны дээд онооны 60 доошгүйг авсан нөхцөлд элсэгчийг онооны жагсаалтад оруулна.

Онооны жагсаалтыг ерөнхий шалгалтын оноон дээр ур чадварын шалгалтын оноог дагалдах хичээлээр тооцно.

- 3.11. МУБИС-ийн ректорын урилгаар элссэн элсэгчийн ур чадварын шалгалтын оноог 800-д тооцож элсүүлнэ.
- 3.12. Сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд болон бусад байгууллага, хувь хүмүүсээс олгох тэтгэлэг, урамшуулал, тусламж авах, хөнгөлөлт эдэлнэ.
- 3.13. Суралцагч нь "МУБИС-ийн Сургалтын журам"-ын 4.5.8-д заасан шаардлагыг хангасан тохиолдолд өөрийн хүсэлтээр тухайн чиглэлээр 2 дахь мэргэжил эзэмшиж болно.
- 3.14. Сургуулийн захиргаанд хандан, багшийн ёс зүй болон сургалтын чанарыг сайжруулах талаар шаардлага, санал хүсэлт тавих эрхтэй.
- 3.15. Суралцагч сургуулиас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх бол "МУБИС-ийн Сургалтын журам"-ын 4.9, түр хугацаагаар суралцах боломжгүй тохиолдолд тус журмын 4.2.3, 4.2.4, 4.2.5, 4.2.6, 4.2.7 заалтын дагуу асуудлаа шийдвэрлүүлнэ.
- 3.16. Суралцагч нь Боловсролын тухай хууль, Дээд Боловсролын тухай хууль, сургуулийн дүрэм, журам, сургалтын хөтөлбөр, оюутны ёс зүйн дүрэм, эрх зүйн бусад актыг чанд мөрдөнө.
- 3.17. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан ЭМД-ын тухай хуулийн дагуу 18 нас хүрсэн тохиолдолд оюутан ЭМД-ын жилийн төлбөр болох 50400 төгрөгийг төлж, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан байна.
- 3.18. Сургуулийн байр, анги танхимын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, номын сангийн ном, сурах бичиг, бусад хэвлэмэл материал зэрэг өмч хөрөнгийг хайрлан хамгаалж, ариг гамтай хэрэглэнэ.
- 3.19. Улирлын хичээл эхэлснээс 4 долоо хоногийн дотор суралцагч сургуулиас чөлөөлөгдөх тохиолдолд "МУБИС-ийн сургалтын журам"-ын 4.9.2-т зааснаар төлбөрийн 75 хувийг буцаан олгоно. 5 ба түүнээс дээш долоо хоног өнгөрсөн тохиолдолд тухайн улирлын төлбөрийг буцаан олгохгүй.
- 3.20. Улирал дууссанаас хойш 14 хоногт багтаж сургуулиас гарах хүсэлт ирүүлсэн тохиолдолд дараагийн улирлын төлбөрийг буцааж олгоно. 14 хоногоос хэтэрсэн бол дараа улирлын төлбөрийн 25 хувийг төлнө.
- 3.21. Суралцагч нь хүндэтгэх шалтгаангүйгээр сургуулиас гарсан, өөр сургуульд шилжсэн тохиолдолд сургалтын төлбөрийн тэтгэлгийг буцааж төлнө.
- 3.22. Засгийн газрын тогтоолд заасан хөнгөлөлт тэтгэлэгт хамрагдаж байсан суралцагчид холбогдох засгийн газрын тухайн тогтоолд өөрчлөлт орсон, хүчингүй болсон тохиолдолд сургалтын төлбөрийн зөрүүг суралцагч өөрөө төлнө.



- 3.23. Суралцагч нь сургалтын үйл ажиллагаанаас гадна сургуулийн захиргаа, тэнхим, албад, оюутны байгууллагаас зохион байгуулж байгаа бусад үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.
- 3.24. Суралцагч нь бүрэлдэхүүний сургууль хооронд шилжин суралцах бол 30%, гаднын сургуулиас шилжин суралцах бол 50% тэнцэх төлбөр төлнө.
- 3.25. Суралцагч нь хүндэтгэх шалтгаангүйгээр дараагийн улиралд судлах хичээл сонголт-1 -ийг заасан хугацаанд хийгээгүй тохиолдолд нэмэлт үйлчилгээний төлбөр 30.000 төгрөг төлнө.
- 3.26. Элсэгч нь бакалавр, магистрантур, докторантурын элсэлтийн бүртгэлийн хураамж 30.000 төгрөгийг төлнө.
- 3.27. Бакалаврын элсэгчдээс бичиг баримт буцаан авах тохиолдолд үйлчилгээний хураамж 100.000 төгрөгийг төлнө.

#### **ДӨРӨВ. БУСАД ЗҮЙЛ**

- 4.1. МУБИС нь энэ гэрээний "Хоёр"-т заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд суралцагчдад учирсан аливаа гэм хорыг зохих журмын хүрээнд шийдвэрлэнэ.
- 4.2. Суралцагч энэ гэрээний "Гурав"-т заасан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж хохирлыг барагдуулна.
- 4.3. Энэхүү гэрээг талууд тус бүр нэг хувь хадгална.
- 4.4. Элсүүлэн суралцуулах тушаал гарсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр болно.
- 4.5. Гэрээний хэрэгжилтийн талаар гарсан маргааныг хоёр тал эв зүйгээр хэлэлцэн шийдвэрлэнэ. Шийдвэрлэх боломжгүй маргааныг шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

#### **ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:**

|                                  |                         |
|----------------------------------|-------------------------|
| МУБИС-ийг төлөөлж                | Суралцагчийг төлөөлж    |
| Бүрэлдэхүүний сургуулийн захирал | Суралцагч               |
| /гарын үсэг, тэмдэг/             | Суралцагчийн гарын үсэг |

20.... оны ... сарын .... -ны өдөр